Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр хүртлэх зай	Чиглэл	
	Тоносон			Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	
	Уулын бэлд	√		Тачир	√
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	
	Тэгш талд			Бор	
Бусад			Элс	√	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		.	
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		.	

Бусад тэмдэглэл
Дөрвөлжин булш.

Гэрэл зураг



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо		Цаг		Бүртгэгч	А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Ц.Буянхишиг
-------	--	-----	--	----------	--------------------------------------

Дурсгалын дугаар	34	Хайгуулын талбайн нэр	Чойр-Арвайхээр
Хайгуулын талбайн хэмжээ	481 км	Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар	

Аймаг	Өвөрхангай		Дурсгалын төрөл	Дөрвөлжин булш	
Сум	Тарагт		Он цаг	Хүрэл зэвсгийн үе	
Солбицол	N46 23 21.4 E102 50 42.9		Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1762			Сайн	
Хэмжээ	Голч			Дунд	√
	Уртрагийн дагуу	2,90 м		Муу	
	Өргөргийн дагуу	3,50 м			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар		

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр хүртлэх зай	Чиглэл	
	Тоносон			Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	
	Уулын бэлд	√		Тачир	√
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	
	Тэгш талд			Бор	
Бусад			Элс	√	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		.	
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		.	

Бусад тэмдэглэл
Дөрвөлжин булш. Голдоо том чулуун дараастай.

Гэрэл зураг



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо		Цаг		Бүртгэгч	А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Ц.Буянхишиг
-------	--	-----	--	----------	--------------------------------------

Дурсгалын дугаар	35	Хайгуулын талбайн нэр	Чойр-Арвайхээр
Хайгуулын талбайн хэмжээ	481 км	Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар	

Аймаг	Өвөрхангай		Дурсгалын төрөл	Хиргисүүр	
Сум	Тарагт		Он цаг	Хүрэл зэвсгийн үе	
Солбицол	N46 23 21.9 E102 50 43.6		Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1761			Сайн	
Хэмжээ	Голч			Дунд	√
	Уртрагийн дагуу	20,2 м		Муу	
	Өргөргийн дагуу	19,90 м			
Дагуул байгууламж	Тоо	2	Гэрэл зургийн дугаар		

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр хүртлэх зай	Чиглэл	
	Тоносон			Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт	√		Дунд	
	Уулын бэлд			Тачир	√
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	
	Тэгш талд			Бор	
Бусад			Элс	√	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		.	
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		.	

Бусад тэмдэглэл

Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр. 20,2 х 19,90 м. 4 булангийн байгууламж сайн хадгалагдсан. Голын дараас 10,50 м диаметр, 1 м өндөр. Хойд талдаа 2 дагуул байгууламжтай.

Гэрэл зураг



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо		Цаг		Бүртгэгч	А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Ц.Буянхишиг
-------	--	-----	--	----------	--------------------------------------

Дурсгалын дугаар	36	Хайгуулын талбайн нэр	Чойр-Арвайхээр
Хайгуулын талбайн хэмжээ	481 км	Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар	

Аймаг	Өвөрхангай		Дурсгалын төрөл	Шоргоолжин булш	
Сум	Тарагт		Он цаг	Хүрэл зэвсгийн үе	
Солбицол	N46 23 22.6 E102 50 44.9		Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1759			Сайн	
Хэмжээ	Голч			Дунд	√
	Уртрагийн дагуу	7,70 м		Муу	
	Өргөргийн дагуу	5,80			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар		

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр хүртлэх зай	Чиглэл	
	Тоносон			Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	
	Уулын бэлд	√		Тачир	√
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	
	Тэгш талд			Бор	
Бусад			Элс	√	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		.	
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		.	

Бусад тэмдэглэл

Шоргоолжин булш. Битүү дараастай. Зүүн талын хашлага том чулуугаар хавиргалан босгож үйлдсэн.

Гэрэл зураг



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо		Цаг		Бүртгэгч	А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Ц.Буянхишиг
-------	--	-----	--	----------	--------------------------------------

Дурсгалын дугаар	37	Хайгуулын талбайн нэр	Чойр-Арвайхээр
Хайгуулын талбайн хэмжээ	481 км	Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар	

Аймаг	Өвөрхангай		Дурсгалын төрөл	Хиргисүүр	
Сум	Тарагт		Он цаг	Хүрэл зэвсгийн үе	
Солбицол	N46 23 20.4 E102 50 54.6		Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1757			Сайн	
Хэмжээ	Голч			Дунд	√
	Уртрагийн дагуу	15,50 м		Муу	
	Өргөргийн дагуу	17,80 м			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар		

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр хүртлэх зай	Чиглэл	
	Тоносон			Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	
	Уулын бэлд	√		Тачир	√
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	
	Тэгш талд			Бор	
Бусад			Элс	√	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		.	
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		.	

Бусад тэмдэглэл

Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр. 4 булангийн байгууламж үлдсэн. Хэмжээ 15,50 х 17,80 м, голын дараас 8,50 м, өндөр 1 м.



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо		Цаг		Бүртгэгч	А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Ц.Буянхишиг
-------	--	-----	--	----------	--------------------------------------

Дурсгалын дугаар	38	Хайгуулын талбайн нэр	Чойр-Арвайхээр
Хайгуулын талбайн хэмжээ	481 км	Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар	

Аймаг	Өвөрхангай		Дурсгалын төрөл	Хиргисүүр	
Сум	Тарагт		Он цаг	Хүрэл зэвсгийн үе	
Солбицол	N46 23 25.4 E102 50 50.2		Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1765			Сайн	
Хэмжээ	Голч			Дунд	√
	Уртрагийн дагуу	10,20 м		Муу	
	Өргөргийн дагуу	12,50 м			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар		

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр хүртлэх зай	Чиглэл	
	Тоносон			Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	
	Уулын бэлд	√		Тачир	√
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	
	Тэгш талд			Бор	
Бусад			Элс	√	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		.	
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		.	

Бусад тэмдэглэл

Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр. 4 булангийн байгууламж үлдсэн. Хэмжээ 10,20 х 12,50 м, голын дараас 5,20 м, өндөр 0,70 м.



ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо		Цаг		Бүртгэгч	А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Ц.Буянхишиг
-------	--	-----	--	----------	--------------------------------------

Дурсгалын дугаар	39	Хайгуулын талбайн нэр	Чойр-Арвайхээр
Хайгуулын талбайн хэмжээ	481 км	Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар	

Аймаг	Өвөрхангай		Дурсгалын төрөл	Дөрвөлжин булш	
Сум	Тарагт		Он цаг	Хүрэл зэвсгийн үе	
Солбицол	N46 23 25.6 E102 50 45.7		Хадгалалт	Маш сайн	
ДТД өндөр	1761			Сайн	
Хэмжээ	Голч			Дунд	√
	Уртрагийн дагуу	2,90 м		Муу	
	Өргөргийн дагуу	3,30 м			
Дагуул байгууламж	Тоо		Гэрэл зургийн дугаар		

Өөрчлөлт	Малтсан		Гол, горхи, сайр хүртлэх зай	Чиглэл	
	Тоносон			Зай	
Газрын тогтоц	Уулын оройд		Ургамал	Өндөр	
	Уулын налуу энгэрт			Дунд	
	Уулын бэлд	√		Тачир	√
	Голын (жалганы) дэнж (эрэг) дээр		Хөрс	Хар	
	Тэгш талд			Бор	
Бусад			Элс	√	

Түүвэр олдвор					
Чулуун зэвсэг		Чулуужсан яс		
Ваарны хагархай		Төмрийн баас		.	
Хүрэл эдлэл		Чулуун эдлэл		
Төмөр эдлэл		Бутлуур чулуу		.	

Бусад тэмдэглэл
Дөрвөлжин булш.

Гэрэл зураг



**Дурсгалын замын трасст өргөж болзошгүй
дурсгалуудын байршил**

Д/д	Солбилцол	Замын цэг	Замын тэнхлэгээс дурсгал хүртэлх зай	Нэмэлт мэдээлэл-Замын трасст
1	N46 16 33.3 E108 23 12.3	6+200 – 6+400	599 м	Өртөөгүй
2	N46 17 22.7 E108 19 40.0	10+800 – 11+000	214 м	Тэмдэг, тэмдэглэгээ
3	N46 17 41.9 E108 15 27.0	16+600	165 м	Тэмдэг, тэмдэглэгээ
4	N46 14 42.5 E108 07 20.9	28+600	81 м	Анхаарах
5	N45 55 35.0 E106 40 04.7	154+500	28 м	Өртсөн
6	N45 55 11.9 E106 39 01.5	156+000 – 156+100	10 м	Өртсөн
7	N45 51 06.1 E106 26 55.8	174+000	75 м	Анхаарах
8	N45 50 18.5 E106 21 29.2	181+800	17 м	Өртсөн
9	N45 47 51.5 E105 55 56.5	217+500	45 м	Өртсөн
10	N45 47 51.2 E105 55 56.1	217+500	55 м	Өртсөн
11	N45 47 50.5 E105 55 56.9	217+500	72 м	Анхаарах
12	N45 47 48.1 E105 55 52.2	217+500	171 м	Тэмдэг, тэмдэглэгээ
13	N45 48 00.4 E105 55 26.2	218+000	45 м	Өртсөн
14	N45 48 05.9 E105 55 04.2	218+500	142 м	Тэмдэг, тэмдэглэгээ
15	N45 48 06.8 E105 55 04.6	218+500	170 м	Тэмдэг, тэмдэглэгээ
16	N45 48 07.0 E105 55 04.9	218+500	177 м	Тэмдэг, тэмдэглэгээ
17	N45 48 07.2 E105 55 05.4	218+500	185 м	Тэмдэг, тэмдэглэгээ
18	N45 48 07.0 E105 55 06.0 N45 48 07.0 E105 55 10.0 N45 48 07.6 E105 55 13.1	218+500	180 м 195 м 222 м	Бүлэг оршуулгын газар-Анхаарах
19	N45 53 49.9 E105 38 36.1	243+600	222 м	Тэмдэг, тэмдэглэгээ
20	N45 56 32.6 E104 29 57.9	335+700	299 м	Тэмдэг, тэмдэглэгээ
21	N45 56 21.2 E104 08 35.0	364+800	275 м	Тэмдэг, тэмдэглэгээ
22	N46 05 26.0 E103 48 48.5	396+300	1 м	Өртсөн
23	N46 05 43.1 E103 47 40.6	397+800	78 м	Анхаарах

24	N46 05 49.9 E103 47 14.0	398+500	47 м	Өртсөн
25	N46 07 51.4 E103 29 10.7	422+600	242 м	Тэмдэг, тэмдэглэгээ
26	N46 07 49.1 E103 29 09.9	422+600	173 м	Тэмдэг, тэмдэглэгээ
27	N46 07 57.7 E103 28 42.5	423+200	74 м	Анхаарах
28	N46 07 58.0 E103 28 43.1	423+200	89 м	Анхаарах
29	N46 23 08.6 E102 50 59.8	480+500	42 м	Өртсөн
30	N46 23 08.9 E102 50 59.1	480+500	48 м	Өртсөн
31	N46 23 16.0 E102 50 45.2	480+800	133 м	Тэмдэг, тэмдэглэгээ
32	N46 23 21.0 E102 50 42.6	481+000	74 м	Анхаарах
33	N46 23 21.2 E102 50 42.8	481+000	68 м	Анхаарах
34	N46 23 21.4 E102 50 42.9	481+000	61 м	Анхаарах
35	N46 23 21.9 E102 50 43.6	481+000	40 м	Өртсөн
36	N46 23 22.6 E102 50 44.9	481+000	3 м	Өртсөн
37	N46 23 20.4 E102 50 54.6	480+800	110 м	Анхаарах
38	N46 23 25.4 E102 50 50.2	481+000	141 м	Тэмдэг, тэмдэглэгээ
39	N46 23 25.6 E102 50 45.7	481+100	71 м	Анхаарах
40	Худаг, өвөлжөө	351+400	75 м	Айлын худаг- Анхаарах

III. АВТОЗАМ ТАВИГДАХ БҮС НУТАГТ ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

III.1. ДУНДГОВЬ АЙМГИЙН НУТАГТ ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

Чулуун зэвсгийн судалгаа. 1969 оноос тус бүс нутагт чулуун зэвсгийн судалгаа эхэлсэн хэмээн үзэж болох бөгөөд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн дурсгал судлах анги Өндөршил, Гурвансайхан сумын заагт орших Ярх уулнаас олдсон дугариг, гурвалжин хэлбэрийн зэвсэг, хусуур, болхи хийцтэй нарийн тал нь хавтгай мэс зэргээр хуучин чулуун зэвсгийн доод үед холбогдоно хэмээн үзжээ [МЗТСХЭ 1969].

1970 онд тус шинжилгээний анги [МЗТСХЭ 1970] Дундговь аймгийн Ярх уулын чулуун зэвсгийн сууринд дахин нарийвчилсан судалгаа явуулсан байна. Ярх уулын чулуун зэвсгийн дурсгал нь доод палеолитын ашеллийн үед буюу 300.000–500.000 жилийн тэртээд холбогдох чулуун зэвсгийн дарханы газар юм. Энэхүү дарханы газар Африк, Европын ашеллийнхтэй ижил сонгодог хэлбэрийн “гилбэр” зэвсэг хийдэг байжээ. Энэ нь өрнө дахинд (Африк, Европ) сонгодог “гилбэр” зэвсгийн соёл, дорно дахинд (Ази) “хугадас” зэвсгийн соёл өөрөөр хэлбэл, доод палеолитын үед хүн төрөлхтөн эрс тэс хоёр өөр соёлтой байсан, түүнтэй уялдан хүн төрөлхтний хөгжил нь өөр байсан мэт үзэж ирсэн хуучин чулуун зэвсэг судлалд ноёрхож байсан онолд няцаалт өгсөн юм [Окладников 1986; Дорж, Цэвээндорж 1978].

1971 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах анги Дундговь аймгийн Хулд, Дэрэн сумдын нутгаар хайгуулын ажил гүйцэтгэж үлдэц, хусуур, ялтас, залтас зэрэг чулуун зэвсгийн олдворууд илрүүлжээ [МЗТСХЭ 1971].

1972 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах анги Дундговь аймгийн төв Мандалговь хотоос 60 км зайд орших Ёроол говь хэмээх хотгороос цахиур зэвсэг үйлдэж байсан дарханы газар шинээр илрүүлэн олсон байна [МЗТСХЭ 1972]. Дээрх онуудын судалгааны үр дүнг нэгтгэн А.П.Окладников, Д.Дорж нар эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна [Окладников 1977:3-13].

1973 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн дурсгал судлах анги Дундговь аймгийн Цахиур толгой, Цагаан худаг, Цагаан Өндөр зэрэг газруудад хайгуул хийж чулуун зэвсгийн үеийн бууц сууринг шинээр илрүүлжээ [МЗТСХЭ 1973].

Булш оршуулгын судалгаа. 1957 онд Монголын ууган археологич Х.Пэрлээ Дундговь аймгийн Зүүнбүрэн, Сайхан сумын нутагт малтсан хоёр булшны хэрэглэгдэхүүн болон түүнд тулгуурласан он цагийн талаар өгүүлэл хэвлүүлсэн байна [Пэрлээ 1956:40-48]. Мөн онд тэрээр дундад зууны монголчуудын хот сууринг шинжлэх явцдаа, Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Тахилын усны суурингийн хойно орших зарим булшийг малтан шинжилжээ [Пэрлээ 1961:94].

1959 онд В.В.Волков Дундговь аймгийн нутгаар хайгуул судалгааны ажил хийж Хаан хэмээх ууланд монголын үеийн булш малтан шинжилсэн байна [Волков 1963:43-55]. Энэхүү малтлага судалгаагаар дүгрэг үзүүртэй төмөр зэв зэрэг эд өлгийн дурсгалт зүйлс илрүүлжээ. Мөн тэрээр Өндөршил сумын Тас уулын орчим, Мандалговь хотын дэргэдэх болон Дэлгэрхангай сумын нутагт өөр малтлага судалгааны ажил гүйцэтгэсэн байна [Волков 1957:37-38].

1981 онд Т.Санжмятав Дэлгэрцогт сумын нутаг Бага газрын чулуунд дөрвөлжин булш малтаж шавар савны хагархай, алтан бөгж, улаан будагтай малын яс, оюу сувс зэрэг зүйлс олсон бол Д.Наваан хүннү булш малтан судалж хүн судлалын материал, эд өлгийн зүйлс илрүүлэн олжээ [Наваан, Санжмятав 1981]. 1985 онд Д.Наваан мөн Бага газрын чулуунд хоёр хадны оршуулга малтсан талаар мэдээ бий [Наваан 1985].

1988 онд МЗТСХЭ-ийн хүрэл, төмрийн түрүү үе судлах ангийнхан Дэл уулын Баруун Билүүний хадны зургийг судлах явцдаа 32 хүний дүрс бүхий хөшөө чулуутай булшийг малтан судалсан байна [Санжмятав 1988].

1990 онд Д. Наваан Дундговь аймгийн Сайхан Овоо сумын нутаг Хайрханд нэг, Замбага хайрхан ууланд хоёр, монголын үед холбогдох гурван булш малтжээ [Лхагвасурэн 1994:53-54; Наваан 1999:23]. Мөн онд Д. Наваан, Дундговь аймгийн ОНС Музейн эрхлэгч Мөнхбаяр, ажилтан Цэрэндорж нар хамтран Сайхан Овоо сумын Хаалган хадны Хангинах гэдэг газар байсан хадны оршуулгыг малтсан байна [Наваан 1999:23].

1990 онд Монгол-Унгар-Зөвлөлтийн хамтарсан “Хүннүгийн дурсгал судлах анги” Бага газрын чулууны Дунд Шандын аманд нэг хүннү булш малтан судалж нумын гичрийн ясан наалт, чагтан тээгтэй бүсний хүрэл арал, хүрэл товруу, хүрэл үзүүрийн чимэг, авсны төмөр чимэглэл, шавар савны хагархай зэрэг эд өлгийн зүйлс илрүүлэн олжээ [Цэвээндорж 1990, Цэвээндорж 2000:35-60].

2005 онд Ц.Амгалантөгс, Ч.Амартүвшин нар Бага газрын чулууны Алаг толгойн хүннү булшнаас нумын наалтан дээрх сараачмал дүрсний талаар тусгайлан хэвлүүлсэн байна [Амгалантөгс нар 2005].

2007 онд П.Хатанбаатар нарын судлаачид Бага газрын чулууны Ихэрийн аманд малтан судалсан хүннү булшнаас гарсан харь гаралтай ховор олдворын талаар өгүүлэл нийтлүүлжээ [Хатанбаатар нар 2007]. Мөн онд Б.Эрдэнэ, Ц.Амгалантөгс, Р.Нельсон нар 2004 онд Бага газрын чулуунд малтан шинжилсэн Алаг толгой, Дагвын даваа, Монголын ар зэрэг газарт малтан шинжилсэн хүрэл, хүннү, дундад зууны үеийн булшны хэрэглэгдэхүүнийг хэвлүүлсэн байна [Эрдэнэ нар 2007].

2007 онд Р.Нельсон, В.Ханичёрч, Ч.Амартүвшин нар Бага газрын чулууны Бага Монгол хэмээх цогцолбор дурсгалын малтлага судалгааны үр дүнгийн талаар илтгэл хэлэлцүүлжээ [Nelson et al. 2007]. Мөн онд В.Ханичёрч, Р.Нельсон, Ч.Амартүвшин нар БНСУ-ын Сөүл хотноо болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд Бага газрын чулуунд хийсэн хүннү булшны судалгааны талаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна [Honeychurch et al. 2007].

2008 онд Ч.Амартүвшин, Б.Жаргалан нар Бага газрын чулуунд хийсэн хүрэл зэвсгийн түрүү үеийн үеийн булшны судалгаагаар нэг өгүүлэл [Амартүвшин нар 2008а], Ч.Амартүвшин, П.Хатанбаатар нар Бага газрын чулууны Хүрэн хондын хүннү булшны судалгааны хэрэглэгдэхүүнээр нэг өгүүлэл [Амартүвшин нар 2008б] тус тус хэвлүүлэн гаргажээ.

2008 онд Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил, Баянжаргалан сумдын нутаг, дахь “Хараат”, “Хайрхан” хэмээх уул уурхайн ашиглалтын талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэж олон тооны дурсгалыг илрүүлэн олсон байна [Гүнчинсүрэн нар 2009].

2010 онд судлаач Р.Мөнхтулга, С.Хүрэлсүх нар Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутаг Оюут Овоо дахь “Гольден Погада” ХХК-ны ашиглалтын талбайд авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэж нийт 100 гаруй дурсгал илрүүлэн олсон байна [Мөнхтулга нар 2010].

Хадны зургийн судалгаа. Энэ төрлийн судалгаа тухайн бүс нутагт харьцангуй сайн хийгдсэн хэмээн үзэж болно. Хамгийн анх 1960 онд Өлзийт сумын Тагт багийн нутагт орших Дэл уулын хадны зургийн дурсгалыг анх 1960 онд А.П.Окладников, Д.Дорж нарын удирдсан Монгол-Зөвлөлтийн шинжилгээний анги илрүүлэн олжээ [Дорж, Новгородова 1975].

Мөн А.П.Окладников Дэл уулын хадны зургийн зарим дүрслэлийн талаар өөрийн номондоо нийтэлсэн байна [Окладников 1981]. Мөн тэрээр Өлзийт сумын хуучин төвийн орчмын нутаг нэгэн хавцлын хаданд дүрсэлсэн шовх чихтэй, өргөн дөрвөлжин хоншоортой, нүд болон хүзүүн дээр нь хоёр дугуй хонхорыг товгороор хүрээлж “алим”

мэт дүрсэлсэн бүдүүн хөлтэй, урт сүүлтэй, сэлдийг нь зориуд цохон дүрсэлсэн азарганы зургийг их эртний шинжтэй өвөрмөц зураг хэмээн шинэ чулуун зэвсгийн үед холбогдуулан, янгир, чоно зэрэг бусад зургийг түүний хажуу завсар зайд хожим дүрсэлсэн гэж үзжээ [Окладников 1981].

1969 онд Д.Дорж, Э.А.Новгородова нар Дэл уулын хадны зургийг дахин нягтлан үзэж улмаар “Петроглифы Монголии” (УБ.,1975) бүтээлдээ харьцангуй баялаг зурагтай гурван уулыг Дэлийн Зүүн Билүү I, II, III хэмээн дугаарлаж янгир, чоно, адуу, морь тэмээ унасан хүмүүс зэрэг 50 орчим зургийг, мөн Өлзийт сумын хуучин төвийн хажуугийн хоёр хавцлаас янгир, чоно, адуу, тэмээ, хүн зэрэг 20 орчим зургийг нийтэлсний дотор хоёр гэрийн зураг буй нь нэн сонирхолтой хэмээн тодорхойлжээ [Дорж, Новгородова 1975]. Мөн тэд Баянжаргалан сумын Цагаан айраг, Өлзийт сумын Дэлийн зүүн бэл, Дэлгэрцогт сумын нутаг Бага газрын чулууны хадны зургийн талаар дээрх бүтээлдээ оруулсан байна [Дорж, Новгородова 1975]. Бага газрын чулууны Гэр хад хэмээх олон тооны хадны зурагтай дурсгалыг А.П.Окладников [1981], Т.Санжмятав [1995] нар судлан тэдгээрийн он цагийг неолит ба хүрэл зэвсгийн үеэр тогтоосон байна.

1979 онд МЗТСХЭ-ийн бичээс судлалын анги Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Бичигт хадны руни, перс, монгол, хятад бичээс, тамгануудыг нягтлан шинжилсэн байна [МЗТСХЭ 1979].

1987 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Санжмятав, МУИС-ийн багш Д.Хүүхэнбаатар нар Дэл уулын Өлзийтийн хуудас хэмээх газар буй “32 хөшөөт булш”-ийг илрүүлж, улмаар түүний ойр орчимд буй хадны зургийг судалжээ. Уг булш нь 3.6 х 4.7 метрийн хэмжээтэй дөрвөлжин булш байсан бөгөөд энэ булшны хашлага чулуун дээр бүжиглэж буй хүмүүс, буга, согоо, шувуу, нум сумтай хүн, хөтлөлцөж яваа эрэгтэй, эмэгтэй хоёр хүн, ан амьтан зэргийг сийлж дүрсэлсэн байжээ [Санжмятав 1988].

1989 онд МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангийнхан Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг Билүүт уулын хадны зураг, Өлзийт сумын Тариат багийн нутаг Отготын амны гурван хэсэг газар хаданд бичигдсэн түрэг бичээс, Билүүт уулын түрэг бичээсийг хуулж авсан байна [Баяр, Эрдэнэбаатар 1989].

Т.Санжмятав 1995 онд хэвлүүлсэн “Монголын хадны зураг” номондоо Өлзийт сумын Тагт багийн нутаг Дэл уулын Баруун Билүүн, Хамар ус, Гучин хоёр хүн хөшөөт зэрэг газрын хадны зургаас товч тодорхойлолт, тайлбарын хамт хэсэгчлэн нийтэлсэн байна [Санжмятав 1995].

Мөн “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал” номын зураг бэлдэх шинжилгээний ангийнхан Дэл уулын зүүн Билүүний хадны зургаас хөтлөлцөн зогссон олон хүн, барилдаж буй хоёр бөхийн зургийг авч уг номонд нийтэлсэн байна [Монгол нутаг 1999:38-39].

1960-аад оноос хойш МУИС-ийн Түүхийн тэнхимээс жил бүр зохион явуулсан оюутны хээрийн дадлагын ажлын хүрээнд профессор Д. Хүүхэнбаатарын удирдлагаар Дундговь аймгийн нэлээд хэдэн сумдын нутагт түүхийн олон үед хамаарах хөшөө дурсгал, булш хиргисүүр, хадны сүг зураг, бичээсийг илрүүлэн заримаас нь нийтлүүлсэн байна [Хүүхэнбаатар 2008:11-31].

2005 онд Д.Цэвээндорж, Н.Батболд нар Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг дахь Дэл уулын Зүүн болон Баруун Билүүний дөрвөн хэсэг газрын хадны зургийг оролцуулан “Дундговь аймгийн Дэл уулын Билүүний хадны зураг” нэгэн сэдэвт зохиол нийтлүүлсэн байна [Цэвээндорж нар 2005].

2007 онд Ж.Врайт, Ч.Амартүвшин нар Бага газрын чулуунаас олдсон түрэгийн үед холбогдох тамга тэмдгийн байршил зүй, зүй тогтолын талаар туршиц судалгааны ажлаа эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлжээ [Wright 2007: 349-365].

2010 онд Г.Галдан, Б.Жаргалан нар Бага газрын чулууны хадны зурагт дүрсэлсэн тамга тэмдгийн зүйлсийн талаар тусгайлан өгүүлэл хэвлүүлсэн байна [Галдан нар 2010].

Мөн онд судлаач Г.Галдан “Дундговь аймгийн нутагт хийсэн археологийн судалгаа Бага газрын чулуу” хэмээх судалгааны бүтээлд Монгол-Америкийн хамтарсан төслийн хүрээнд 2003-2008 озуудад Бага газрын чулуунд хийсэн археологийн нарийвчилсан хайгуул судалгааны явцад Босгын хоолой, Монгол уул, Очирт хүрээ, Өндөр хонд, Рашаант, Сөдөтийн хоолой, Тахилт гэсэн долоон газраас шинээр илрүүлсэн хадны зургийн дурсгалыг нийтэлсэн байна.

Хот суурины судалгаа. Монголын ууган археологич Х.Пэрлээ 1951 онд “Краткое сообщение о древностях около Их-Газарын чулуу” гэдэг бүтээлдээ Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дахь Тахилын усны сууринд хийсэн судалгааны талаар анх нийтлүүлсэн байна [Пэрлээ 1951]. Үүний дараа “Монгол Ард Улсын хот суурины товчоон” (1963) бүтээлдээ дээрх хотод хийсэн малтлага судалгаа болон он цагийн талаар дэлгэрэнгүй оруулжээ [Пэрлээ 1963].

Хүн чулууны судалгаа. 1984 онд Монгол орны дорно болон өмнө хэсэгт ажилласан хээрийн шинжилгээний ангийнхан Дундговь аймгийн ОНС музейд хадгалагдаж буй 2 хүн хөшөөг судлан эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан байна [Мэнэс 1995:73-86].

Мөн судлаач Д.Баяр “Монголчуудын чулуун хөрөг” (1995) нэгэн сэдэвт бүтээлдээ дээрх хоёр хөшөөний талаар дахин нягтлан хэвлүүлсэн байна [Баяр 1995].

Бичиг үсгийн дурсгалын судалгаа. 1964 онд Б.Базылхан Дундговь аймгийн нутгаас олдсон нэгэн тамганы бичээсийг тайлан уншиж нийтлүүлсэн байна [Базильхан 1964:74-75].

1987 онд МЗТСХЭ-ийн Хүрэл, төмрийн түрүү үе судлах ангийнхан Дэл уулын Баруун Билүүний хадны зургийг судлах явцдаа эртний түрэг бичээс буйг олж илрүүлсэн байна [Санжмятав 1987].

1997 онд судлаач Ц.Баттулга Дэл уулын Баруун Билүүний амны эхэнд орших Булаг Билүүтэйн хурал турийн арын сархинаг мэт дэл хаданд буй 4 бичээсийг нягтлан хуулбарлаж 2, 3 дугаар бичээсийг тайлан уншиж нийтэлжээ [Баттулга, 1998:109-115].

2004 онд Бага газрын чулууны Ханангийн бууц хэмээх газраас шинээр илрүүлсэн түрэг бичээсийг судлаач Ц.Баттулга тайлан уншиж нийтлүүлжээ [Амартүвшин нар 2004].

Түүвэр олдворын судалгаа. Н.Сэр-Оджав нар Дундговь аймгийн орон нутгийг судлах музейн үзмэрт байгаа 400 гаруй хүрэл түүвэр олдворыг судлан тэдгээрийг зэвсгийн зүйл, аж ахуйн хэрэгцээний зүйл, гоёл чимэглэлийн зүйл, тодорхой хэрэгцээний зүйл хэмээн дөрвөн хэсэгт хувааж ангилан он цагийг тогтоосон байна [Сэр-Оджав нар 1964].

2003 онд судлаач Д.Батсүх Дундговь аймгийн нутгаас түүвэрлэсэн зарим хүрэл олдворын цуглуулгыг ангилан боловсруулжээ [Батсүх, 2004].

III.2. ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ БАЙДАЛ

Өвөрхангай аймгийн нутаг нь археологийн нэн арвин дурсгалтай бөгөөд үүнийгээ дагаад энэ чиглэлийн судалгаа шинжилгээ нилээд хийгдсэн аймгуудын тоонд зүй ёсоор ордог билээ. Чулуун зэвсгийн үеийн судалгааг 1949 онд С.В. Киселевын үндэс суурийг нь тавьсан Монгол-Зөвлөлтийн түүх-этнографийн хамтарсан экспедицийн бүрэлдхүүнд А.П. Окладниковын удирдсан чулуун зэвсгийн дурсгал судлах анги ажиллаж, Хиагтаас Улаанбаатараар дайран баруун зүг Хар хорин хүртэл, зүүн тийш Хэрлэн, Халх голын сав газраар, өмнө зүгт улсын хил хүртэл хайгуул судалгаа хийж палеолитын үед холбогдох олон арван шинэ дурсгалуудыг илрүүлсэн байна.

Эдгээрийн дотроос хамгийн сонирхолтой нь Хархорины дэргэдэх Мойлтын амны суурин байсан бөгөөд Умард Ази, Сибирийн палеолитын чулуун зэвсгийн шинж төрхийг санагдуулахуйц олон зуун эдлэлүүдийг хөрсөн дээрээс олж цуглуулан, малтлага хийж амжаагүй байна. 1950-1956 онуудад Монголын археологичид Ховд, Өвөрхангай, Архангай, Говь, Булган, Дорноговь аймгийн нутгуудаас палеолитын үеийн олон арван бууц суурингууд илрүүлсэн нь Байгал нуур, Хиагтын орчмын палеолитын үеийн эдлэлтэй туйлын ижил шинжтэй байгаад тулгуурлан Монгол оронд амьдарч байсан эртний хүмүүс хөрш зэргэлдээ Сибирийн эртний хүмүүстэй тодорхой хэмжээний харилцаа холбоотой байсан гэсэн дүгнэлтийг хийж байжээ. 1955 онд археологич Ц. Доржсүрэн Өвөрхангай аймгийн Богд, Гучин-Ус сумдын нутгаас үлдэц, захын болон төгсгөл ир бүхий хусуур зэргийг түүвэрлэн илрүүлэн олжээ.

1960-1966 онд А.П. Окладников, Д. Дорж нарын удирдсан монгол зөвлөлтийн археологичдын бүрэлдэхүүнтэй Монголын чулуун зэвсгийн дурсгал судлах анги манай улсын бараг бүх аймгийн нутгийг хамарсан хайгуул судалгаа явуулж, хуучин чулуун зэвсгийн дунд, дээд үе, шинэ чулуун зэвсгийн үеийн дурсгал олон газраас олж илрүүлснээс Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, мөн 1960, 1961, 1964 онуудад Өвөрхангай аймгийн Хархорины сангийн аж ахуйн нутаг Орхон голын хойт дэнжид буй Мойлтын амны дөрвөн соёлт давхрага бүхий палеолитын үеийн сууринг малтан шинжилснээр Төв, Умард Азийн хэмжээнд нэн ховор дурсгал болох нь тодорхой болсон юм. Эдгээр малтлага хайгуулын ажлын үр дүнд сонирхолтой өгүүллүүд нийтлэгдэн гарсан билээ. 1985 онд МЗТСХЭ-ийн А.П. Деревянко, Д. Дорж нарын удирдсан чулуун зэвсэг судлалын анги Өвөрхангай аймгийн Хархорины нутагт Орхон голын Мойлтын ам, Бат-Өлзийт сумын Билүүт, Баянхонгор аймгийн Түйн голын Их Булган зэрэг газар палеолит, неолитын суурин малтан судлаж, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь, Дундговь аймгуудын нутгаар өргөн цар хүрээтэй хайгуул хийснээр 166 газраас палеолит, неолитын чулуун зэвсэг нийтдээ 14 000 гаруйг цуглуулжээ.

1996-1997 онд Монгол-Францын хамтарсан палеолитын шинжилгээний анги Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Мойлтын аманд орших олон соёлт давхарга бүхий сууринг археологи, геологийн талаар дахин судалжээ.

Хүрэл ба төмрийн түрүү үеийн судалгаа нь 1948-1949 онд Оросын судлаач С.В. Киселевийн удирдсан экспедици Монголын эртний нийслэл Хархорумыг малтах үедээ Өвөрхангай аймгийн Хужиртын амралтын орчим хэдэн дөрвөлжин булш малтсаны дараа 1956 онд Н. Сэр-Оджав Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шунхлай ууланд дөрвөлжин булш нэгийг малтжээ.

1962 онд В.В. Волков Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулын орчимд дөрвөлжин булш хоёр, МЗТСХЭ-ийн хүрэл ба төмөр зэвсгийн дурсгал судлах анги 1971 онд Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын Тэмээн чулууны аманд хэд хэдэн дөрвөлжин булш, 1976 онд Архангай аймгийн Их Тамир сумын Шивэртийн аманд 4 дөрвөлжин булш малтан шинжилсэн билээ.

МЗТСХЭ-ийн хүрэл ба төмөр зэвсгийн дурсгал судлах анги 1976-1983 онд Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шунхлай уул, Зүйл сумын Наран толгойд малтаж зарим нэг эрдэм шинжилгээний эх хэрэглэгдэхүүнийг олжээ.

Хүрлийн үед холбогдох хадны зургийн судалгаа нь 1948-1949 онд С.В. Киселев, Х. Пэрлээ нарын удирдсан түүх-угсаатны зүйн экспедицийн бүрэлдэхүүнд К.В. Вяткина, БНМАУ-ын Шинжлэх Ухааны хүрээлэнгийн ажилтан Г. Багаева нар ахласан угсаатны зүйн анги ажилласны үр дүнд Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шунхлай уулаас хагас километр зайд орших Тэхийн гэр гэдэг хаднаа зургаан янгирын зургийг илрүүлэн олсноор эхэлжээ. Дурдсан экспедицүүдийн бүрэлдэхүүнд ажилласан А.П. Окладников, Шинжлэх Ухааны хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Б. Жаргалсайхан нарын удирдсан Палеолитын дурсгал судлах анги Өвөрхангай аймгийн Ховд (одоогийн Богд) сумын Тэвш уулнаа янгир, могой, хүмүүс зэргийг цоолборлосон хадны зургийн томоохон дурсгал, Улаанбаатараас зүүн хойш 30 км орчимд орших Гачууртын амны хаднаа улаан зосоор тоймлон зурсан хүн, адуу, шувуу зэргийн зургийг илрүүлэн олжээ.

Хүннү булшны талаархи судалгаа нь 1960-1970-аад онд Д. Наваан Зөвлөлтийн болон Унгарын археологчдын хамт Өвөрхангай аймгийн Ховд багийн Тэвш уул болон бусад аймгуудын нутагт хүннү булш малтжээ. Археологич Д. Цэвээндорж 1970-аад оны үеэс хүннүгийн оршуулгын дурсгалыг дагнан судлах болсон билээ. Тэрээр Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш ууланд 8 булшийг, 1986 онд Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Онътолтод 17 хүннү булш илрүүлэн 1-ийг малтан шинжилж олдвор хэрэглэгдэхүүнийг нь нийтэлсэн юм. Монгол-Унгар-Зөвлөлтийн хамтарсан Хүннүгийн дурсгал судлах анги 1989 онд Өвөрхангай аймгийн Зүйл сумын Тарвагатай, Хужирт сумын Хүүшийн хөтөлд тус бүр 1 хүннү булш малтаж нилээд тооны эд өлгийн зүйлс олсон билээ.

Хүн чулуун хөшөөг 1909 онд Финлянд улсын монголч эрдэмтэн Г.И. Рамстедт, эртний судлаач С. Пяльси нар Арвайхээр хотоос урагш 15-16 км зайтай Ноён тал хэмээх газарт буй хээтэй хавтан чулуун хашлага болон нэг нь нарийн ур хийцтэй, нөгөө нь болхидуухан, хоёр хүн чулууны гэрэл зургийг нийтэлсэн бөгөөд эдгээр нь одоо Өвөрхангай аймгийн ОНС музейн фондод бий. 1909-1910 онд Монгол болон Шинжааны нутгаар аялсан Отани ахлагчтай Японы судалгааны ангийнхан Орхон голын хөндийд буй Хөшөө Цайдам, Хар балгасын дурсгалуудыг үзэж, хүн чулууны заримыг тодорхойлон бичсэн нь бий. 1923-1926 онд П.К. Козловын удирдлагаар зохион илгээсэн Монгол-Төвдийн шинжилгээний анги ажлынхаа явцад Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Онгийн голын сав газарт, нутгийн ард олон □Цагаан уушх -г нь Ленинград хотноо аваачжээ. Түүнчлэн П.К. Козлов нь энэ явалтаараа мөн аймгийн Хайрхандулаан сумын нутаг, сумын төвөөс зүүн хойш 26 км-т орших Их модны ам хэмээх газарт буй 2 хүн чулуу, Нарийнтээл сумын нутаг Баянтээгийн нүүрсний уурхайгаас баруун тийш 6-7 км-т Тээг хэмээх уулын баруун өмнө байгаад одоо үрэгдэж алга чулуу□ хэмээн нэршсэн х

1933-1934 онд Д.Д. Букинич Монголын төв нутаг Орхон гол, Хангайн нурууны орчмоор судалгааны ажил гүйцэтгэхдээ Хөшөө Цайдам, Тэрхийн цагаан нуурын дурсгалуудыг үзсэнээс гадна шинээр хэдэн хүн чулуу илрүүлж олсноо тэмдэглэжээ. Үүнд, Орхон голын баруун хөвөө, Хар Хорины эсрэг талд буй Тээлийн аманд хээ угалзгүй хавтан чулууны хамт газарт сул хэвтэх нэг хүн чулуу, Орхонд цутгах Цагаан сүмийн голын баруун эрэг Сүүл толгой хэмээх газарт ихэд гэмтсэн хоёр хүн чулуу, Хөгшин Орхоны эх Шар Бүрд хэмээх газарт нэг хүн чулуу тус тус үзсэнээ тэмдэглэн заримынх нь гар зургийг үйлджээ. 1989 онд Өв хэмээх дурсгалыг үзэж судласан байдаг байна.

Түрэг, Уйгар, Кыргызын булш оршуулгын судалгаа нь мөн л 1948-1949 онд Их Монгол улсын нийслэл Хархорум хотыг малтан судлах ажил гүйцэтгэсэн Монгол-Зөвлөлтийн хамтарсан шинжилгээний ангийн гишүүн Л.А. Евтюхова Орхон голын хөндийд дундад зууны үед холбогдох хэдэн булш малтан шинжилснээр эхлэж, 1965 онд

Монгол улсын ШУА-иас зохиосон Х. Пэрлээ нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний ангийнхан Өвөрхангай аймгийн Уянга сумын Онгийн гол, Хайрхандулаан сумын Хан Хөгшин уул хавийн эртний дурсгалыг гүймэг шинжин үзэхдээ тэр нутагт хадгалагдан үлдсэн зарим хүн чулуун хөшөө, тэдгээрийг нутгийн ард олон хэрхэн нэрлэж, тахиж шүтэж ирсэн талаар судалгаа хийж, бурханы шашин Монголд дэлгэрэхдээ, өмнөх бөө мөргөлийн зан үйлээс зарим зүйлийг уламжлан авч өөрийн зорилгод ашиглаж байсан тухай сонирхолтой өгүүлэл туурвижээ. Тэрвээр, Уянга сумын төвөөс баруун хойш 2 км орчим зайтай байх Хадан хошуу хэмээх хамрын өвөрт байх ²Цагаан уушхай², ард нь байсан ²Хар уушхай² гэж нэрлэдэг хүн чулуудтай холбоотой шүтлэгийн зан үйлийг тусгайлан судалж үзээд, эдгээрийг тахиж, шүтэх, цээрлэх бөө мөргөлийн ёсон, өөрөөр баруун буюу сайн зүгийн 55 тэнгэр, зүүн зүгийн 44 тэнгэр хэмээх үзлээс үүссэн заншил болохыг тэмдэглэсэн байх ба харин он цагийн хувьд түрэгийн үеийн хүн чулуу гэж үзжээ.

Монголын үед холбогдох булшны судалгаа нь 1956 онд Монголын Шинжлэх Ухааны Хүрээлэнд ажиллаж байсан Зөвлөлтийн эрдэмтэн В.В. Волков Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Их Газар хэмээх газар монголын үед холбогдох нэгэн булш малтаж хос эмжээр бүхий торго, гутлын ул, модон самны зэрэг эд өлгийн үлдэгдэл олсон нь эдүгээ Монголын Үндэсний Түүхийн Музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. Гэвч малтлагын баримтжуулалт тайлан хийгдээгүй, булшны материалыг энэ хир нийтлээгүй ажээ.

1964 онд археологич Н. Сэр-Оджав Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Мойлтын аманд гурван булш малтан 65 см урт үйсэн хоромсого, төмөр зэв олсны зэрэгцээ Хархорум хотыг малтахад гарсантай ижил паалантай шаазангийн хагархай олжээ.

1972 онд Монгол-Зөвлөлтийн түүх-соёлын хамтарсан экспедици (В.В. Волков) Өвөрхангай аймгийн Богд сумын Ховд багийн нутаг Бага Тэвш ууланд XIII-XV зууны үед холбогдох хоёр монгол булш малтсан бол, 1976-1980 оны хооронд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт ажилласан БНМАУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн археологийн шинжилгээний анги (Н. Сэр-Оджав, Д. Баяр) Их Монгол Улсын нийслэл Хархорум хотын шороон хэрмийн баруун хойд өнцөгт орших дөрвөлжин далан хэрэм бүхий оршуулгын газрын нэг хэсгийг малтан шинжилж, нийт 37 хүний булш илрүүлэн олжээ. 1978 онд МЗТСХЭ-ийн хүрэл, төмрийн дурсгал судлах анги Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мойлтын аманд нэг монгол булш малтсан байна. 1979 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсэг судлах анги (Д. Цэвээндорж, Ю.С. Худяков нар) Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Бага Арцатын аманд нэг булш малтаж материалыг 1986 онд нийтлэжээ. 1980 онд Өвөрхангай аймгийн Хархорин суманд ажилласан МЗТСХЭ-ийн судлаачид (Д. Баяр, В.Е. Войтов, Г. Мэнэс) Монголын эртний нийслэл Хар Хорум хотын дэвсгэрт орших Халхын Өндөр гэгээн Занабазарын эх Ханджамц хатны дурсгалд зориулан босгосон суварганы баруун хажууд байсан нэгэн булшийг малтаж эмэгтэй хүний оршуулганаас үйсэн богтаг малгай, алтан ээмэг, шавраар хийсэн ээрүүлийн дунгуй, төмөр хутга, найман талтай хүрэл товруу, ширэн гутлын үлдэгдэл зэрэг сонирхолтой олдворууд илрүүлсэн байна. Үүний зэрэгцээ, судалгааны явцад Эрдэнэ зуу хийдээс чанх урагш 1 км зайтай орших, орой дээрээ эртний хэрэмт барилгын үлдэгдэл бүхий Маамуу толгой хэмээх газар санамсаргүй тохиолдлоор илэрч мэдэгдсэн нэгэн булшийг малтаж, эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна. 1986 онд В.В. Волков, Д. Наваан, Т. Санжмятав, Х. Лхагвасүрэн нар Өвөрхангай аймгийн Хархорин сумын Түвшинширээ уулын энгэрт хоёр монгол булш малтжээ. 1989 онд Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан З. Батсайхан Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Орхон голын баруун эрэг Нарийны ам хэмээх газар нэгэн булш малтан судалжээ.

ДҮГНЭЛТ

Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр (Чойр)-сумаас Өвөрхангай аймгийн Арвайхээр сум хүртэлх 481 км хатуу хучилттай авто замын трассын дагуу хайгуул судалгааны ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 21-нээс 09-дүгээр сарын 28-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Судалгааны багийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм эрхлэгч доктор (Ph.D), А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Ц.Буянхишиг нар ажиллав.

Хайгуул судалгааг гүйцэтгэхдээ археологийн шугаман хайгуулын арга, агаарын зургийн хайгуулын аргыг ашиглав.

Хайгуул судалгааны явцад нийт 39 археологийн дурсгал илэрч олсон. Эдгээрээс дараах 12 дурсгал шууд өртөж устах аюултай байна.

1. Дурсгал № 5, 6, 8, 9, 10, 13, 22, 24, 29, 30, 35, 36-д буй дурсгалууд замын трасст шууд өртөж устахаар байна. Эдгээр дурсгалуудыг хуулийн дагуу авран хамгаалах малтлага судалгаа хийж чөлөөлөх эс бөгөөс замын трассыг өөрчлөх шаардлагатай.
2. Дурсгал № 4, 7, 11, 18, 23, 27, 28, 32, 33, 34, 39-д тэмдэглэгдсэн дурсгалуудыг туслах зам тавих, хүнд техникийн хөдөлгөөн зэргээс хамгаалах арга хэмжээг авах шаардлагатай байна.
3. Мөн үлдсэн Дурсгал №1, 2, 3, 12, 14, 15, 16, 17, 19, 20, 21, 25, 26, 31, 37, 38-д буй эдгээр дурсгалыг замын зураг, ажлын зурагт тусган тэмдэглэх, анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ босгох шаардлагатай.

Замын трассыг өөрчлөгдөхгүй тохиолдолд 1-р бүлэгт дурдагдсан дурсгалууд нь аль ч тохиолдолд шинээр баригдах зам, барилгын ажилд өртөн устах аюултай байгаа тул хуулийн дагуу археологийн авран хамгаалах малтлага судалгааг хийж замын трассыг чөлөөлөх шаардлагатай байна.

Мөн түүнчлэн зам барилгад хэрэглэгдэх түгээмэл тархацтай ашигт малтмал болох чулуун болон шорооны карьеруудыг өөрчлөх тохиолдолд тухайн цэгүүдэд дахин археологийн хайгуул, тандалт судалгааг Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу хийх шаардлагатай юм.

Хавсралт1

**ДУРСГАЛЫН ЗАМЫН ТРАССТ ӨРТӨЖ УСТАСТАЖ БОЛЗОШГУЙ
ДУРСГАЛУУДЫН БАЙРШИЛ, АВРАН ХАМГААЛАХ НҮҮЛГЭН
ШИЛЖҮҮЛЭХ, МАЛТАН СУДААХ АЖЛЫН ЗАРДАЛ**

Д/д	Солбилцол	Замын цэг	Замын ТЭНХЛЭГЭЭС ДУРСГАЛ хүргэлх зай
5	N45 55 35.0 E106 40 04.7	154+500	28 м
6	N45 55 11.9 E106 39 01.5	156+000 156+100	10 м
8	N45 50 18.5 E106 21 29.2	181+800	17 м
9	N45 47 51.5 E105 55 56.5	217+500	45 м
10	N45 47 51.2 E105 55 56.1	217+500	55 м
13	N45 48 00.4 E105 55 26.2	218+000	45 м
22	N46 05 26.0 E103 48 48.5	396+300	1 м
24	N46 05 49.9 E103 47 14.0	398+500	47 м
29	N46 23 08.6 E102 50 59.8	480+500	42 м
30	N46 23 08.9 E102 50 59.1	480+500	48 м
35	N46 23 21.9 E102 50 43.6	481+000	40 м
36	N46 23 22.6 E102 50 44.9	481+000	3 м
	Нийт 12 Дурсгалыг МАЛТАН СУДААЖ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЗАРДАЛ		

Жич : Энэ зардалд татвар хураамж бүгд багтсан болно.